



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2376, 7032 2325,
Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn
Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2025. 04. 08 № 1/164
танай _____-ны № _____-т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ**

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн мэдэгдэл, санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2025 оны 1 дүгээр улирлын мэдээг хүргүүлж байна.


Хавсралт хуудастай.

О.ПҮРЭВДОРЖ

6225 15 0148

D:My Doc. A5 albanbichig /ZD/

Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дугаар
сарын 28-ны өдрийн 1167 дугаар
албан бичгийн хавсралт



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛАД
ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ**

2025 оны 01 дүгээр сарын 06

Арвайхээр

Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагуудад хандан ирүүлсэн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2008 оны “Журам батлах тухай” 44 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан “Иргэдээс аймаг, сумын Засаг дарга түүний Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журмын хүрээнд тус тус хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд иргэдээс 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, агентлаг, төсөвт байгууллагуудад хандаж нийт 974 санал, хүсэлт, гомдол ирүүлсэн нь өмнөх оны 1 дүгээр улирлын байдалтай харьцуулахад 67.7 хувиар буурсан байна.

Иргэдээс ирсэн санал, хүсэлт, гомдлыг ирүүлсэн сувгаар нь авч үзвэл: Иргэн өөрийн биеэр 743, байгууллагын тусгай утасны дугаараар холбогдож 27, байгууллагын вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл зэрэг цахим хэлбэрээр 19, Засгийн газрын иргэд, Олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан 19 иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээдээс албан бичгээр 166 иргэн санал, хүсэлт, гомдол ирүүлсэн байна.

Нийт ирсэн 974 санал, хүсэлт, гомдлыг төрлөөр нь авч үзвэл: Хүсэлт 859 буюу 88.1 хувь, гомдол 99 буюу 10.1 хувь, санал 14 буюу 1.4 хувь, мэдэгдэл 2 буюу 0,2 хувийг тус тус эзэлж байна.

1 дүгээр улирлын байдлаар иргэдээс ирүүлсэн нийт 974 санал, хүсэлт, гомдол, мэдэгдэлийг шийдвэрлэлтийн байдлаар нь авч үзвэл: албан бичгээр 130 буюу 13.3 хувь, цахимаар 53 иргэний хүсэлт буюу 5.4 хувийг, утсаар 223 иргэний хүсэлт буюу 22.8 хувийг, биечлэн 481 иргэний хүсэлт буюу 49.3 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилсан. Шийдвэрлэх шатандаа буюу хуулийн хугацаа болоогүй 86 иргэний хүсэлтийг судалж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд шийдвэрлэлт 91,6 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн хуулийн хүрээнд түргэн шуурхай шийдвэрлсэн хугацааны хувьд ангилан үзэхэд: Ажлын 5-15 хоногт 280, 15-30 хоногт 501 30-60 хоногт 106 иргэний хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна. Холбогдох харьяаллын дагуу 1 иргэний хүсэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад харьяалалын дагуу шилжүүлэн тухайн иргэнтэй холбогдож мэдээлэл хүргэсэн.

Нийт ирүүлсэн санал, хүсэлт, гомдлын агуулгад дүн шинжилгээ хийж үзэхэд: Тусламж дэмжлэг хүссэн 13 хувь, Боловсролын үйлчилгээтэй холбоотой 17хувь, Амьдрах орчин нөхцөлтэй холбоотой 15 хувь, Нийгмийн салбартай холбоотой 22 хувь, Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 15 хувь, бусад салбарт 18 хувь нь ирүүлсэн байна. Мөн аймгийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудын долоо хоног бүрийн Шуурхай хуралдаан тогтвортой хуралдаж 2025 оны 1 дүгээр улиралд нийт 6 удаа хуралдаж, төрийн үйлчилгээ мэдээллийн төвөөр дамжуулан иргэдээс ирүүлсэн гомдол, хүсэлт, түүний шийдвэрлэлтийн байдлыг хэлэлцэж, аймгийн удирдалгаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар: Аймгийн Засаг даргын Тамгын газар 2025 оны 1 дүгээр улиралд нийт 51 иргэний хүсэлт, гомдлыг бүртгэж авсан байна. Үүнээс 50 нь хүсэлт, 1 иргэний гомдлыг бүртгэж авсан байна. Хуулийн хугацаанд албан бичгээр 4 иргэний, холбогдох утсаар нь 3 иргэний, биечлэн 38 иргэний хүсэлтийг шийдвэрлэн нийт 45 иргэний хүсэлтийг шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэх шатандаа буюу хуулийн хугацаа болоогүй 6 иргэний хүсэлтийг судалж байна. Иргэдээс ирүүлсэн хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл: Мөнгөн тусламж, дэмжлэг хүссэн 28, ажилд орох, ажлын байраар хангахыг хүссэн 5, өчлөл, эзэмшлийн зориулалтаар газар хүссэн 5, тусгай зөвшөөрөл хүссэн 13 хүсэлт байна. Эдгээрийг ажлын 1-30 хоногт багтаан шийдвэрлэсэн байна. Нийт ирүүлсэн өргөдөл, гомдол нь өмнөх оны мөн үетэй харьцуулхад 3 хүнээр буурсан байгааг хархад өргөдөл гомдлын статистик дүн тогтвортой түвшинд байна.

Сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага: 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 630 иргэний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч бүртгэл судалгаа, шинжилгээн дээр тулгуурлан шийдвэрлэсэн байна. Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлыг өмнөх онтой харьцуулан үзэхэд: 74.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Иргэдийн санал, хүсэлт, гомдлыг ирүүлсэн байдлаар нь авч үзвэл: Өөрийн биеэр 517, байгууллагын тусгай утсаар 26, байгууллагын вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл зэрэг цахим хэлбэрээр 18, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан 6, албан бичгээр 63 иргэн өргөдөл, гомдлоо ирүүлсэн. Үүнийг шийдвэрлэсэн байдлаар нь ангилан үзэхэд: 84 иргэний хүсэлтийг албан бичгээр, 11 иргэний хүсэлтийг цахимаар, 212 иргэний хүсэлтийг холбогдох утсаар, 301 иргэний хүсэлтийг биечлэн хариуг нь өгч шийдвэрлэсэн байна. Бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн 1 иргэний хүсэлт байна. Сумдын Засаг дарга, түүний Тамгын газар болон төсөвт байгууллагуудад нийт 75 гомдол иргэдээс ирүүлсэн бөгөөд үүнийг агуулгаар нь авч үзэхэд: Орчны бохирдол (хог, түүний цэг, бохир ус ил асгах,) холбоотой 27, Золбин нохойтой холбоотой асуудал 11, Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг 3, Зам талбай, замын хөдөлгөөний тэмдэг тэмдэглэгээ, гарцтай холбоотой 7, төрийн байгууллагын үйлчилгээ удааширч байгаа тухай 3, бусад төрлийн гомдол 18 гомдол, Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан 6 гомдол тус тус ирсэн байна. Дээрх гомдлын мөрөөр дүн шинжилгээ хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон тухайн гомдол гаргасан иргэнд хуулийн хугацаанд 30 хоногт багтаан тайлбар хүргүүлж шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг: Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад 2025 оны эхний улирлын байдлаар нийт 293 иргэний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч чирэгдэлгүй хуулийн хугацаанд шийдвэрлэж иргэдэд үйлчилсэн байна. Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлыг өмнөх онтой харьцуулан үзэхэд: 39.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өргөдөл гомдлыг хүлээн авсан хэлбэрээр нь ангилан үзэхэд: 175 иргэн өөрийн биеэр, 1 иргэн утсаар, 1 иргэн цахимаар, Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан 13 иргэн, албан бичгээр 103 иргэний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авсан. Иргэдээс агентлагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь авч үзэхэд: гомдол 23, хүсэлт 268, санал 2 бүртгэгдсэн байна. Үүнээс нийт ирүүлсэн гомдлыг хандсан байгууллагаар нь авч үзвэл: Боловсролын байгууллагад 6, гомдол, Эрүүл мэндийн байгууллагад 6, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 4, Хүнс хөдөө аж ахуйн газарт 2, Цагдаагийн газарт 3, татварын газарт 2 гомдол тус тус ирүүлж дээрх байгууллагуудад ирсэн нийт 23 гомдлыг хуулийн хугацаанд 20 гомдлыг шийдвэрлэсэн. Хуулийн хугацаа болоогүй 3 гомдлыг судлан үзэж байна. Нийт гомдлыг өмнөх оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 30.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд: 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Өвөрхангай аймагтай холбоотой асуудлаар нийт 19 санал, гомдол ирсэн бөгөөд төрлөөр нь авч үзвэл гомдол 17 буюу 89.4 хувь, санал 2 буюу 10.5 хувийг тус тус эзлэж байна. Санал хүсэлтийг хүлээн авах сувгаар нь авч үзвэл утсаар 16, вэб хуудсаар 1, вэб чатаар 1, фэйсбүүкээр 1 иргэн тус тус ханджээ. Салбарын хувьд эрүүл мэндийн салбартай холбоотой 6, цагдаагийн байгууллага 3, барилга, орон сууцтай холбоотой 2, хог хаягдалтай холбоотой 2, татварын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 2, бусад асуудлаар 4

иргэн хандсан байна. Нийт санал, гомдлын 16 буюу 85.0 хувийг хугацаанд нь шийдвэрлэсэн бол 3 буюу 15 хувийг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



**ИРГЭДЭЭС 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СТАТИСТИК МЭДЭЭ**

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр					Нийт
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр	
	1	2		3	4				5	
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн	
Аймгийн Засаг даргын Тамгын газар		1		50	51					51
Агентлагууд		23	2	268	175	1	1	13	103	293
Сумдын Засаг даргын Тамгын газар	2	75	12	541	517	26	18	6	63	630
Нийт	2	99	14	859	743	27	19	19	166	974

2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр					Нийт
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр	
	1	2		3	4				5	

Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн	
Аймгийн Засаг даргын Тамгын газар				54	53				1	54
Агентлагууд		33	10	444	343	10	9	11	114	487
Сумдын Засаг даргын Тамгын газар	11	69	8	2395	1396	43	627	5	412	2483
Нийт	11	102	18	2893	1792	53	636	16	527	3024

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



2025 оны 1 дүгээр улирлын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

ӨВӨРХАНГАЙ	Шийдвэрлэлтийн байдал										Нийт шийдвэрлэсэн
	Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй	
	Албан бичгээр	Дахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо					
	1	2	3	4	5	6					
Аймгийн Засаг даргын Тамгын газар	4		3	38	-	-			6		45
Агентлагууд	42	42	8	142					59		234
Сумдын Засаг даргын Тамгын газар	84	11	212	301	1				21		608
Нийт	130	53	223	481	1	0	0	0	86	0	887

2024 оны 1 дүгээр улирал

ӨВӨРХАНГАЙ	Шийдвэрлэлтийн байдал										Нийт шийдвэрлэсэн
	Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй	
	Албан бичгээр	Дахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо					
	1	2	3	4	5	6					
Аймгийн Засаг даргын Тамгын газар	2		12	37					3		51
Агентлагууд	90	3	62	298	5	1	3		25		456
Сумдын Засаг даргын Тамгын газар	216	513	535	1190					29		2454
Нийт	308	516	609	1525	5	-	3	-	57	-	1590

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2025 СНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ

ӨВӨРХАНГАЙ	ГАРГАСАН ГОМДОЛ (Агуулгаар)				Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
	№	Гомдлын агуулга	Тоо	Хувь	
	1	Боловсролын байгууллага үйл ажиллагаатай холбоотой	6	6.06	
	2	Орчны бохирдолтой холбоотой гомдол	27	27.27	
	3	Нийтийн тээвэр, гэрэлтүүлэгтэй зам талбай, замын тэмдэглэгээ холбоотой гомдол	10	10.10	
	4	байгууллагын үйл ажиллгатай холбоотой	17	17.17	
	5	Тэнэмэл нохой устгалтай холбоотой	11	11.11	
	6	Цахилгаан эрчим хүч, бохирын шугамтай, холбогдолтой үйлчилгээ	7	7.07	
	7	Бусад	21	21.21	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар сургалт мэдээлэл өгөх, арга зүй олгох
	8	Нийт	99	100.00	

2024 он

ӨВӨРХАНГАЙ	№	Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
	1	Боловсролын асуудлаар	20	19.61	
	2	Эрүүл мэндийн чиглэлээр	18	17.65	
	3	Орчны бохирдолтой холбоотой гомдол	23	22.55	
	4	Нийтийн тээвэр, гэрэлтүүлэгтэй холбоотой гомдол	11	10.78	
	5	төрийн албан хаагчийн харилцаа, хандлагатай холбоотой	15	14.71	
	6	төрийн үйлчилгээтэй холбоотой	15	14.71	
	7	Нийт	102	100.00	

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР